



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1990 оны 12 сарын 13

№ 306

Улаанбаатар
хот

Хүүхдийн цэцэрлэгүүд нээн
ажиллуулах тухай

Үйлдвэр, албан байгууллагуудаас ажилчдынхаа хүүхдэд зориулан цэцэрлэг байгуулсан, шинээр цэцэрлэг яслийн барилга баригдан ашиглалтанд орж байгааг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Хотын дүүргүүдэд шинээр ашиглалтанд орсон цэцэрлэгүүдэд 151, 152, 153, 154, 4, 156, 1, 135, 9 дүгээр цэцэрлэг гэсэн дугаарыг тус тус олгож, албан бичгийн хуудас, тамга, бичгийн нүүр хийлгүүлж, хүмүүжих хүүхдийн тоо, бүлэг, ажиллах цаг, нээх хугацааг хавсралтын ёсоор тогтоож ажиллуулахыг Хотын ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-т цаалгасугай.

2. Ашиглалтанд орсон 1, 4, 152, 156, 9, 135 дугаар цэцэрлэг, яслиудын төсвийг батлах санхүүжүүлэхийг Санхүүгийн газар /н.Гонгор/, хүнсний материал болон хөлбөгдөх зардлыг нэмж хуваарилахыг Нийгэм, эдийн засгийн хөгжлийн газар /н.Бат/-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Гутлын үйлдвэр, Био комбинат, Оёлын үйлдвэрийн 151, 153, 154 дүгээр цэцэрлэгийн зардлыг тус тусын үйлдвэрүүдээс нь гаргах нь зүйтэй гэж үзсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Ч.СУМААХҮҮ



Улаанбаатар хотын Ардын Хурлын
Гүйцэтгэх захиргааны 1990 оны
306 дугаар тогтоолын хавсралт

№	Дүүрэг	Цэцэрлэгийн дугаар	Ажил- лах цаг	Бү- лэг	Хүмүү- жүүлэх хугац ноо	Цэцэрлэг байгуулах албан байгууллагын нэр	Нээх хугацаа
1.	Багахангай	I дүгээр цэцэрлэг, ясли	12	8	180	Өндөр толгойн хороонд Зөвлөлтийн суларсан орон сууцны байранд	I/VI
2.	Багануур	4 дүгээр цэцэрлэг, ясли	12	8	190	Багануурын төвд	I/XI
3.	Ажилчин	I51 дүгээр цэцэрлэг	24	4	100	Гутлын үйлдвэрийн ний- тийн орон сууцанд	I/XI
4.	Ажилчин	I52 дугаар цэцэрлэг	12	6	140	Нисэхийн гэр хороололд	20/XII
5.	Ажилчин	I54 дүгээр цэцэрлэг, ясли	12	6	140	Био комбинатад	25/XII
6.	Найрамдал	I53 дугаар цэцэрлэг	24	12	280	Оёдлын үйлдвэр /Амгаланц/	I/XI
7.	Найрамдал	I56 дугаар цэцэрлэг, ясли	12	12	280	Шархацны 9-р хороонд	20/XII
8.	Налайх	9 дүгээр цэцэрлэг	12	6	140	Налайхын уурхай	20/XII
9.	Сүхбаатар	I35 дугаар цэцэрлэг, ясли	12	8	190	XI хороололд	20/XII
		ДҮН	2/7	70	1660		